

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 09 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, ERP системд бүртгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, иргэнд хариу өгөх ажлыг зохион байгуулан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр ажиллаж байна.

Улаанбаатар хотын музейд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар албан хаагчдаас нийт 11 (арван нэг) өргөдөл ирснийг иргэний талд хугацаанд нь шийдвэрлэсэн. Шийдвэрлэлт 100 хувь.

Иргэн, албан хаагчдаас ирсэн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 хоног 12 цаг 14 минут байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагын захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэр болох захирлын тушаалыг программд оруулан хавсаргаж байна.

Музейн захиргаанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтийн ил тод байдлын хуулийг ханган ажиллав.

Музейд ирсэн иргэдтэй холбоотой өргөдөл, хүсэлт, гомдлын шийдвэрлэлт нь:

1. Аавын 10 хоногийн цалинтай чөлөө хүсэх тухай

Музейн жижүүр Ч.Хишигдэлгэр 2025 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр охинтой болсон тул аавын 10 хоногийн цалинтай чөлөө хүссэн. Шинээр төрсөн хүүхдээ асрахад зориулж музейн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу захирлын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/03 дугаар тушаалаар аавын 10 хоногийн цалинтай чөлөө олгосон.

2. Ажилд орох тухай

Н.Ичинхорлоо нь үзмэр харгалзагчийн ажлын байранд ажилд орохыг хүссэн. Музейн захирлын 2025 он 02 дугаар сарын 03-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар үзмэр харгалзагчаар томилж, гурван сарын хугацаатай туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

3. Б.Болдбаатарын ар гэрт буцалтгүй тусламж олгох тухай

Музейн захирлаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан Б.Болдбаатар нь нас барсан тул ар гэрт нь 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Б/09 дугаар тушаалаар нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.

4. Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох тухай

Жижүүр Ж.Хадбаатар нь өндөр насны тэтгэвэрт гарах нас нь болсон тул үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Захирлын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар Ж.Хадбаатарын хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгохоор шийдвэрлэсэн.

5. Буцалтгүй тусламж хүсэх тухай

Бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргал нь халуун усанд түлэгдэж ГССҮТ-д 12 хоног эмчлүүлсэн. Урт хугацааны турш эмчилгээ хийлгэх шаардлагатай болж байгууллагаас буцалтгүй тусламж хүссэн. Музейн захирлын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн Б/15 дугаар тушаалаар буцалтгүй тусламж олгосон.

6. Буцалтгүй тусламж хүсэх тухай

Жижүүр Г.Цолмон нь ГССҮТ-д зүүн гарын гэмтэл хугарлын мэдрэл чөлөөлөх, гарын 5 хуруу, шуу, тохойн хэсэгт хагалгаа хийлгэж хэвтэж эмчлүүлсэн. Урт хугацааны турш эмчилгээ хийлгэх шаардлагатай болж байгууллагаас буцалтгүй тусламж хүссэн. Музейн захирлын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн Б/15 дугаар тушаалаар буцалтгүй тусламж олгосон.

7. Жижүүрээр ажилд орох тухай

Музейн захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн Б/19 дугаар тушаалаар Н.Болорчулуунийг өвчтэй байгаа жижүүрийн оронд түр ажилд авсан.

8. Жижүүрээр туршилтын хугацаатай ажилд авах тухай

Музейн захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар Б.Хүрэлхүүг туршилтын хугацаатай ажилд авсан.

9. Ажилд орох тухай

Иргэн Б.Мөнгөнтуул үзмэр харгалзагчаар ажилд орох хүсэлт гаргасан. Музейн захирлын 2025 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн Б/21 дугаар тушаалаар тухайн ажилд 3 сарын туршилтын хугацаатай томилсон.

10. Ажлаас чөлөөлөгдөх тухай

Жижүүр Г.Цолмон өвчний улмаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Музейн захирлын 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн Б/24 дугаар тушаалаар хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон.

11. Түр ажлаас чөлөөлөгдөх тухай

Н.Болорчулуун жижүүрийн түр ажлын байрнаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Музейн захирлын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Б/25 дугаар тушаалаар чөлөөлөгдсөн.

ХОЁР. МУЗЕЙН ЗАХИРЛЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ

Тайлант хугацаанд иргэдтэй уулзалт хийгдээгүй болно.

ХЯНАСАН:

МЕНЕЖЕР



Б.НАРАНГЭРЭЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АРХИВ, БИЧИГ

ХЭРГИЙН АЖИЛТАН



Д.ГАНТУЛГА